



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/25

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жил”-ийн төлөвлөгөөнд туссан ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төмс, хүнсний ногооны үр худалдан авах зардалд 535,000 (таван зуун гучин таван мянга), “Алтан намар” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах арга хэмжээний зардалд 800,000 (найман зуун мянга) төгрөг, болзолт уралдааны шагналд 2,000,000 (хоёр сая) төгрөг, нийт 3,335,000 (гурван сая гурван зуун гучин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,335,000 (гурван сая гурван зуун гучин таван мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Н.БАТ-ЭРДЭНЭ